

ЭРТНИЙ СЯНЬБЭЙ-МОНГОЛ ТӨРЛИЙН ХЭЛНҮҮДЭЭС ЗҮРЧИД-МАНЖ ХЭЛЭНД ОРСОН ЗАРИМ ҮГИЙН ТУХАЙД

Андрей Шимунек*

Товч агуулга: Зохиогч бээр энэхүү өгүүлэлдээ ном болон бусад судалгааныхаа зарим үр дүнг хураангуйлан оруулсан бөгөөд ШУА-ийн ХЗХ байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлаар 2021 оны 12 дугаар сарын 27-28-ны өдөрт хэлэлцүүлж, одоо өгүүллийн хэлбэрээр уншигч танд хүргэж байна. Зохиогч энэхүү өгүүлэлдээ урт удаан түүхэн хугацаанд сяньбэй-монгол төрлийн хүмүүсийн хэл соёлын гүн нөлөөнд орсон зүрчид-манж хэл соёлын тухай хэлэлцүүлсэн болно. Сяньбэй-монгол төрлийн хэлнүүдээс зүрчид-манж хэлэнд ормол үгсийг энэхүү өгүүлэлд дараах түүхэн давхаргаар авч үзсэн болно. Үүнд, сэрби хэлнээс эртний зүрчид хэлний угтал үеийн хэлэнд орсон үгс; эртний зүрчид хэлэнд орсон хятан хэлний үгс; эртний монгол болон дундад үеийн монгол хэлнээс эртний зүрчид хэлэнд орсон үгс.

Түлхүүр үг: сяньбэй, сяньбэй-монгол хэлний овог, зүрчид-манж хэл, манж-түнгүс төрлийн хэлнүүд, хятан буюу кидан хэл, ормол үгс, түүхэн хэл шинжлэл

1. Удиртгал

1.1. Сяньбэй-монгол төрлийн хэлнүүд

Юуны өмнө “сяньбэй” буюу “ширви” гэдэг эртний үндэстний нэрийн учрыг тайлбарлая. Сяньбэй гэдэг ханзаар галиглагдсан үндэстний нэрийг эртний хятад хэлний дуудлагаар сэргээвэл уг хэлбэр нь *сэрби байна. (Энэ нь Слав төрлийн серби хэл биш гэдгийг анхаарна уу). Монгол хэлний өвөг дээдэс гэж нэрлэж болох өвөг *сэрби буюу сяньбэй-монгол хэл (англиар бол Proto-Serbi-Mongolic language) урт удаан түүхтэй. Сяньбэй хэлнүүд нь хятадын Цинь болоод Хань хаант улстай хиллэдэг байсан Дун Хү (монголчилбол, Дорнод Хү) гэдэг үндэстний хэлнээс эхэлсэн байж магадгүй (Шимунек, 2017). Сяньбэй-монгол төрлийн хүмүүс (Serbi-Mongolic peoples)


* БНСУ, ТЭЖОН, ҮСУН ИХ сургууль, Эндикоттийн нэрэмжит Олон улс судлалын сургууль.
ashimune@alumni.iu.edu

олон зуун жилийн туршид Монголын өндөрлөг болон Хятадын зүүн хойд нутгийг ноёрхож байжээ. Сяньбэй-монгол хэлний овгийн хэлнүүд нь анх Хань хаант улсын үед хүний нэр болон бусад ономастик баримтаар дурдагдсан байдаг (Шимунек, 2017: 38-77; Шимунек, 2018a).

Авиан зүйн галигтай, орчуулгатай үгс үлдээсэн сяньбэй төрлийн хэлнүүд гэвэл:

- **Табгач** (табгач ~ тоба) хэл м.э. III-VI зуун.
- **Тойгон** (түюйхунь ~ тогон ~ аша) хэл, м.э. III-VIII юм уу, X зуун хүртэл.
- **Хятан** буюу **кидан** (цидань) хэл, IV зууны үед анх дурдагдаад XIII зуун хүртэл.
- **Ширви** буюу шывэй, м.э. VI-IX зуун.

зэрэг хэлнүүд байсан байна. (Шимунек, 2017; Шимунек, 2018a). Зохиогч бээр 2017 онд бичсэн *Languages of Ancient Southern Mongolia and North China* гэдэг номдоо монгол төрлийн хэлнүүдийн шинэ овгийн мод (*language family tree*) гаргасан.



Зураг №1. Сяньбэй-монгол хэлний овгийн мод (Шимунек 2017)

1.2. Зүрчид-манж хэл

Манж үсгээр бичигдсэн хамгийн эртний түүхэн судруудад манжчууд өөрсдийгөө *manju* “манж” биш, харин *jušen* “зүрчид” (1621-1622, 1623 он) гэдэг байсан байна. Энэ нь зүрчид үндэстний нэр бөгөөд зүрчид үсгээр бол ингэж бичнэ:

叟 𡗗

Зураг №2. “Зүрчид” гэдгийг зүрчид үсгээр бичсэн нь

Дундад болон хожим үеийн зүрчидээр *jušen* гэж дууддаг. Эртний зүрчид хэлбэрийг нь **juršen* гэж сэргээвэл зүйтэй. Эртний зүрчид хэлний **juršen* гэдэг үгэнд олон тоо заасан “-д” нөхцөл залгаж, монгол хэлний “зүрчид” гэдэг үг үүссэн байна (Лигети, 1953).

Манж хэлний *manju* ‘манж’ гэдэг үндэстний нэрийг манжийн Хунтайж хаан буюу Hong Taiji (1628-1643 он) самгард хэлний *Mañju-śrī* ‘манзшир’ гэдэг буддын нэрээс үндэс авч зохиосон бөгөөд энэ зохиомол үндэстний нэр нь “зүрчид” гэдэг уугуул үндэстний нэрийн оронд үндэстний шинэ нэр болжээ (Беквит, 2009-ийг үзнэ үү). Манж хэлний *manju* гэдэг үг анх 1636 онд бичигдсэн бичээст дурдагдсан бөгөөд *manjura*- гэдэг үүсмэл үйл үгийн хэлбэрээр тохиолдсон байдаг. Өөрөөр хэлбэл, “манж” бол хожим үеийн зүрчид хэл, “зүрчид” бол эртний манж хэл гэсэн үг (Гертраудэ Рот Ли-гийн 2000 онд бичиж хэвлүүлсэн манж бичгийн сурах бичгийг үзнэ үү).

Өөрөөр хэлбэл, манж, зүрчид гэж хоёр хэл биш, харин нэг хэлний хоёр түүхэн үе шат байна. Зүрчид бол эртний манж хэл, хожим үеийн зүрчид хэл бол манж хэл гэж ойлгож болно. Иймээс зохиогч бээр энэхүү илтгэлдээ энэ хэлийг “зүрчид-манж хэл” (Jurchen-Manchu) гэж нэрлэж байна.

2. Сяньбэй-Монгол төрлийн хэлнүүдээс зүрчид-манж хэлэнд орсон үгс

Сяньбэй-монгол төрлийн хэлнүүдээс зүрчид-манж хэлэнд ормол үгс элбэг байдаг гэж хэлж болно. Эдгээр үгийг таван түүхэн давхаргаар хувааж болно. Үүнд:

1. Эртний сяньбэй-монгол төрлийн хэлнүүдээс эртний өмнөд түнгүс төрлийн хэлнүүдэд орсон үгс;
2. Ширви хэлнээс эртний зүрчид хэлний угтал үеийн хэлэнд орсон үгс;
3. Эртний зүрчид хэлэнд орсон хятан хэлний үгс;
4. Эртний монгол болон дундад үеийн монгол хэлнээс эртний зүрчид хэлэнд орсон үгс;
5. Орчин цагийн монгол хэлний угтал үеийн хэлнээс хожим үеийн

зүрчид буюу манж хэлэнд орсон үгс.

Зүрчид хэлэнд орсон монгол үгсийн тухай Поппе (1979) анх цухас судалсан нь энэ талаарх судалгааны хүрээг нээсэн гэж хэлж болно. Поппегийн тэр өгүүлээс өмнө ихэнх судлаачид дээр үеийн зүрчид хэлний баримт биш, харин манж хэлэнд үлдсэн үгийн сангийн баримтыг л судалж байсан гэж хэлж болно. Жишээлбэл, Санжеев (1930), Цинциус (1975-1977), Ружицкий (1994) нарын чухал хувь нэмэр оруулсан бүтээлүүд нь манж хэлэнд орсон эртний монгол үгсийг тодорхойлсон байна.

1977 онд японы зүрчид хэл судлаач Киёсэ Гисабуро зүрчид үсгийг дэлгэрэнгүй тайлж, зүрчид хэлний авиан зүйн талаар их хувь нэмэр оруулсан. Тэр материал нь одоогийн судлаачдад зүрчид хэлний баримтыг эх хэлбэрээр нь судлах боломж олгосон. Киёсэ Гисабуро, Цзинь Гуанпин, Цзинь Цицун зэрэг судлаачийн бүтээлд нэмэлт засвар оруулбал, одоо энэ хамгийн эртний баримтыг судалж болно.

Зохиогч бээр 2017 онд хэвлүүлсэн номдоо зүрчид-манж хэлэнд орсон сяньбэй-монгол хэлний үгсийн тухай товч дурдсан бөгөөд номынхоо дараа хэвлүүлсэн зарим өгүүлэлдээ өөр зарим ормол үг олж тодорхойлсон билээ. Өнөөдрийн энэхүү илтгэлдээ өмнө нь олсон бөгөөд саяхан шинээр олсон зарим үгсийн тухай хэлэлцүүлж байна.

Энэ үгсийн зарим нь шууд эртний монгол хэлнээс гаралтай биш, харин монгол хэлний үеэл хэл байсан хятан хэл болон хятан хэлтэй төрөл байсан бусад хэлнүүдээс гаралтай (Шимунек, 2017; 2018a).

2.1. Эртний сяньбэй-монгол төрлийн хэлнүүдээс зүрчид-манж хэл болон бусад өмнөд түнгүс төрлийн хэлнүүдэд орсон зарим үгсийн тухайд

Энэ үгийн сангийн түүхэн давхаргын ормол үгс нь уламжлалт багаж хөдөлмөрийн зэмсэг, нэхмэл бүтээгдэхүүн, байгаль болон байгалийн баялаг, тооны үг, шашин шүтлэг, эртний болон дундад үеийн харилцаа холбооны тогтолцоо, зарим хийсвэр ойлголтууд, үйл үг болоод өөр олон утга зүйн аймагтай холбоотой болно.

Нэг сонин жишээ гэвэл, Зүрчид хэлний 11-ээс 19 хүртэл тооны үгс нь эртний сяньбэй-монгол хэлний овогт харьяалагдсан ширви хэлнээс гаралтай байх магадлал өндөр байна (Шимунек, 2018a).

МАНЖ		Зүрчид		Ширви буюу шывэй	сяньбэй-монгол төрлний хэлний үгийн гарал
安朔	<i>omšon</i> (<i>omšon biya</i> “11-р сар”)	< 七 七	* <i>omšon</i> [安朔 歡] “11”	← * <i>amš</i> -хэн < ? * <i>amš</i> “нэг” + * <i>хэн</i> “арав” (← ЭТүр. аялгууны * <i>hon</i> “10”)	< сяньбэй хэлний юйвэнь аялгууны * <i>amš</i> ~ * <i>maš</i> “нэг” > хятан * <i>mas</i> “нэг”
兒兒	<i>joryon</i> (<i>joryon biya</i> “12-р сар”)	< 尔	* <i>jirхэн</i> [兒兒 歡] “12”	← * <i>jir</i> -хэн “12” < * <i>jir</i> “2” + * <i>хэн</i> “10” (← ЭТүр. аялгууны * <i>hon</i> “10”)	< ӨСМ * <i>jir</i> “хоёр” > хятан * <i>čur</i> ~ * <i>jur</i> “хоёр”, ДМо. <i>jiri-n</i> “хоёр” (<i>LASM</i>)
		口	* <i>goryon</i> [戈兒 歡] “13”	← * <i>gur</i> -хэн “13” < * <i>gur</i> “3” + * <i>хэн</i> “10” (← ЭТүр. аялгууны * <i>hon</i> “10”)	< ӨСМ * <i>gur</i> “3” > хятан * <i>gur</i> ~ * <i>qur</i> , ДМо. <i>qurba-n</i> (<i>LASM</i>)
		工 儿	* <i>durхэн</i> [獨兒 歡] “14”	← * <i>dur</i> -хэн “14” < * <i>dur</i> “4” + * <i>хэн</i> “10” (← ЭТүр. аялгууны * <i>hon</i> “10”)	< ӨСМ * <i>dor</i> “4” > ДМо. * <i>dur</i> , ДМо. <i>dörbe-n</i> (cf. ЭТүр. <i>tört</i> ~ <i>dört</i> ← Тохар Б хэлнээс гаралтай, <i>LASM</i> 336-337)

Хүснэгт №1. Ширви хэлнээс зүрчид-манж хэлэнд орсон тооны үгс “11-14”
(Шимунек, 2018a)

脱卜	<i>tofoxon</i> “15”	< 五	* <i>toboxon</i> [脱卜 歡] “15”	← * <i>tabu</i> -хэн “15” < * <i>tabu</i> “5” + * <i>хэн</i> “10” (← ЭТүр. аялгууны * <i>hon</i> “10”)	< ӨСМ * <i>ḥabu</i> “5” > хятан * <i>taw</i> , ДМо. <i>tabu-n</i> (<i>LASM</i>)
泥渾	<i>ñolxun</i> ~ <i>ñolxun</i> “1-р сарын 16-ны өдөр”	< 二	* <i>nilxun</i> [泥渾] ~ * <i>ñolхэн</i> [女魯 歡] “16”	← * <i>ñir</i> -хэн “16” < * <i>ñir</i> “6” + * <i>хэн</i> “10” (← ЭТүр. аялгууны * <i>hon</i> “10”)	< ? ӨСМ * <i>ñir</i> “зургаа” > ДМо. <i>ñirgo-a-n</i> “зургаа”
		工	* <i>dalхэн</i> [答兒 歡] “17”	← * <i>dal</i> -хэн “17” < * <i>dal</i> “7” + * <i>хэн</i> “10” (← ЭТүр. аялгууны * <i>hon</i> “10”)	< ӨСМ * <i>dalU</i> “7” > ДМо. <i>dolo'a-n</i> “7”, ДМо. <i>dalu-n</i> “70”, хятан * <i>dalU</i> “7” (<i>LASM</i>)
		方	* <i>ñuxun</i> [女渾] “18”	← * <i>ñu</i> -хэн ~ * <i>ñew</i> -хэн “18” < * <i>ñu</i> /* <i>ñew</i> “8” + * <i>хэн</i> “10” (← ЭТүр. аялгууны * <i>hon</i> “10”)	< ӨСМ * <i>ñayima</i> “8” > хятан * <i>ñem</i> “8”, ДМо. <i>naima-n</i> “8” (<i>LASM</i>)

Хүснэгт №2. Ширви хэлнээс зүрчид-манж хэлэнд орсон тооны үгс “15-18”
(Шимунек, 2018a)

МАНЖ		Зүрчид		Ширви буюу шывэй	сяньбэй-монгол төрлний хэлний үгийн гарал
		七	* <i>ñoxon</i> [幹女 歡] “19”	← * <i>amš</i> - <i>ñu</i> -хэн (?) ~ * <i>amš</i> - <i>ñew</i> -хэн < * <i>amš</i> “1” + * <i>ñu</i> ~ * <i>ñew</i> “8” + * <i>хэн</i> “10” (← ЭТүр. аялгууны * <i>hon</i> “10”)	(v. <i>supra</i>)

Хүснэгт №3. Ширви хэлнээс зүрчид-манж хэлэнд орсон тооны үг “19”
(Шимунек, 2018a)

Зүрчид-манж хэлний *orin* “хорь” болоод *gošin* “гуч” гэдэг тооны үг мөн эртний сяньбэй-монгол хэлнээс гаралтай болохыг өмнөх судлаачид тодорхойлсон байна.

Эдгээрээс гадна олон өөр жишээ байгаа боловч цагийн хязгаарлалтаас болоод зохиогч бээр товчхон дурдахаар шийдлээ.

2.2. Эртний зүрчид хэлэнд орсон хятан хэлний зарим үг

Зүрчид үндэстэн нь Хятан хаант улсыг эзлээд хятанчуудын бичиг үсгийн уламжлалыг өвлөж авсан байна. Тэр үед хятан хэлнээс зүрчид хэлэнд орсон үг олон байна. Эдгээрийн ихэнх нь *Цзинь Шы* (“Алтан улсын түүх”) хэмээх сударт хятад ханзны галигаар уламжлагдаж ирсэн байна. Мөн хятан хэлнээс бүтээвэр бүтээврээр зүрчид хэлэнд орчуулагдаж ирсэн үгс (англиар илэрхийлбэл, “calque” буюу “loan translations”) орсон байна. Заримыг нь авч үзье.

ДЗүр. **cauši* “цэргийн жанжин” < ЭЗүр. **caurši* ← хятан **cawrši* (1084 онд босгосон Салбар уулын бичээс, Шимунек, 2022).

Ма. *цооха* (Цин улсын үеийн ярианы манж хэлний **cauḥa*) “цэрэг” < ДЗүр. **cauḥa* ← хятан **cawḥ* (Шимунек, 2017: 331-332).

Ма. *fon* “цаг, улирал” < ДЗүр. <*fo.on*> < ЭЗүр. **rɔn* ← хятан **rʰɔ* “цаг улирал” < ӨСМ **rʰɔ* > ДМо. *hon* “он” (Шимунек, 2017: 361).

Ма. *gurun* < ДЗүр. *gurun* < <*guru.un*> < ЭЗүр. **gurun* (*Цзинь Шы*) ← эртний СМ, cf. хятан **gur-ən* < **gur* ‘country, state’ + *-*ən* ‘genitive’ (Шимунек, 2017: 346).

ЭЗүр. **ṇayrsai* “нар сар” (*Цзинь Шы*) < орчин цагийн монгол хэлний “нар сар” гэдэгтэй гарал нэг болох хятан хэлний **ṇayr* “нар” гэдгээс зүрчид хэлэнд орсон.

2.3. Эртний болон дундад үеийн монгол хэлнээс зүрчид болон бусад түнгүс хэлнүүдэд орсон үгс

Монголчууд 1234 онд зүрчидийн Алтан улсыг эзэлсний дараа зүрчид хэл нь монгол хэлний нөлөөнд гүнзгий автсан байна. Харин энэ үед зүрчид хэлэнд орсон монгол үгийн ихэнх нь зүрчид эхээрээ сайн судлагдаагүй байгаа юм. Зарим үг нь эртний болон дундад үеийн зүрчид хэлэнд байж байгаад хожим үеийн зүрчид хэл буюу манж хэл үүсэхээс өмнө мөхсөн бөгөөд үлдсэн хэсэг нь манж хэлэнд уламжлагдаж үлдсэн юм байна. Олон жишээ байдаг. Үүнээс нэг жишээ дурдъя.

Ма. *bitxə* < ДЗүр. *bitixə* < ЭЗүр. ← ЭМо. **bitig* ← ЭТүр. *bitig* ‘id.’ ← сири *pitqā* ← грек *πίττακιον* ‘writing tablet’. Орчин цагийн монгол хэлний “бичиг”. Энэ “бичиг” гэдэг үг нь эртний грек хэлнээс сири, түрэг зэрэг хэлээр дамжаар монгол хэлэнд ороод эртний монгол хэлнээс зүрчид-манж

хэлэнд орсон түүхтэй (Синор, 1978; Шимунек, 2018b).

3. Төгсгөлийн үг

Дээр дурдсан жишээнүүдээс харвал сяньбэй-монгол төрлийн хэлнүүд урт удаан түүхэн хугацаанд зүрчид-манж хэлэнд өргөн хэмжээгээр гүнзгий нөлөө үзүүлсэн байна. Зохиогч бээр энэ сэдвээр гүнзгийрүүлсэн судалгаа явуулж буй бөгөөд тус судалгааны үр дүн удахгүй англиар хэвлэгдэнэ.

Summary

This paper is a significantly abbreviated version of a presentation delivered by the author in Mongolian at the Mongolian Academy of Sciences on December 27-28, 2021. In this article, the author discusses some examples of the deep and profound Serbi-Mongolic influences on the Jurchen-Manchu language. This article briefly addresses the following historical layers of Serbi-Mongolic loanwords in Jurchen Manchu: loanwords from the Shirwi language into Archaic Jurchen; Kitan loanwords in Old Jurchen; and Old Mongol as well as Middle Mongol loanwords in Jurchen.

Ном зүй

Beckwith, Christopher I. (2009). *Empires of the Silk Road: A History of Central Eurasia from the Bronze Age to the Present*. Princeton: Princeton University Press.

Kara, György (1977). Хятан бичгийн хоёр тогтолцооны тухай. *Олон улсын монголч эрдэмтний III их хурал*. Улаанбаатар: Олон улсын монголч эрдэмтний их хурлын байнгын хороо. Х. 86-89. [Kara, György (1977). On the two Kitan writing systems. *Third International Congress of Mongolists*. Ulaanbaatar: Permanent Committee of the International Congress of Mongolists. P. 86-89.]

Kara, György (1987). On the Khitan writing systems. *Mongolian Studies*, 10. P. 12-24.

Kara, György (1996). Siniform scripts in Inner Asia: Kitan and Jurchin. *The World's Writing Systems*. Ed. Peter T. Daniels and William Bright. Oxford. P. 230-238.

Kara, György (2005). *Books of the Mongolian Nomads: More than Eight Centuries of Writing Mongolian*. Bloomington: Research Institute for Inner Asian Studies, Indiana University.

Kiyose, Gisaburo N. (1977). *A Study of the Jurchen Language and Script: Reconstruction and Decipherment*. Kyoto: Horitsubunkasha.

Kane, Daniel (1989). *The Sino-Jurchen Vocabulary of the Bureau of Interpreters*.

Uralic and Altaic Series, Volume 153. Bloomington, Indiana: Indiana University Research Institute for Inner Asian Studies.

Kane, Daniel (2006). Khitan and Jurchen. *Manchu Studies in Honour of Giovanni Stary*. Ed. Alessandra Pozzi. Wiesbaden: Harrassowitz Verlag. P. 122-132.

Kane, Daniel (2009). *The Kitan Language and Script*. Leiden: Brill.

Campbell, Lyle (1999). *Historical Linguistics: An Introduction*, Cambridge: MIT Press.

Li, Bing (1996). *Tungusic Vowel Harmony: Description and Analysis*. Amsterdam: Universiteit van Amsterdam.

Li, Gertraude Roth (2000). *Manchu: A Textbook for Reading Documents*. Honolulu: University of Hawaii Press.

Ligeti, Louis (1953). Note préliminaire sur le déchiffrement des “petits caractères” joutchen. *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*. Volume 3, Number 2. P. 211-228. [Ligeti, Louis (1953). Preliminary note on the decipherment of the Jurchen “small script”. *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*. Volume 3, Number 2. P. 211-228.]

Norman, Jerry (1977). The evolution of Proto-Tungusic *t to Manchu s. *Central Asiatic Journal*, Volume 21. P. 229-233.

Norman, Jerry (1978). *A Concise Manchu-English Lexicon*. Seattle: University of Washington Press.

Poppe, Nicholas (1979). Jurchen and Mongolian. *Studies on Mongolia: Proceedings of the First North American Conference on Mongolian Studies*. Ed. Henry G. Schwarz. Bellingham: Western Washington University. P. 30-37.

Rozycki, William (1994). *Mongol Elements in Manchu*. Indiana University Uralic and Altaic Series, Volume 157. Bloomington, Indiana: Indiana University Research Institute for Inner Asian Studies.

Санжеев, Гарма Д. (1930a). Маньчжуро-монгольские языковые параллели. Часть первая. *Известия АН СССР, отделение гуманитарных наук*, сер. VII, No 8. X. 601-626. [Sanzheev, Garma D. (1930a). Manchu-Mongolian linguistic parallels. Part 1. *Proceedings of the USSR Academy of Sciences, Department of Humanities*. Series VII, Number 8. P. 601-626.]

Санжеев, Гарма Д. (1930b). Маньчжуро-монгольские языковые параллели. Часть вторая. *Известия АН СССР, отделение гуманитарных наук*, сер. VII, No 9. X. 673-708. [Sanzheev, Garma D. (1930b). Manchu-Mongolian linguistic

parallels. Part 2. *Proceedings of the USSR Academy of Sciences, Department of Humanities*. Series VII, Number 9. P. 673-708.]

Синор = Sinor, Denis (1978). *Altaica and Uralica. Studies in Finno-Ugric Linguistics in Honor of Alo Raun*. Ed. Denis Sinor. Bloomington. P. 319-332.

Сүнъ Бозцюнъ = Sun Bojun (2004). *Jindai nüzhenyu*. Beijing. [Sun Bojun (2004). *The Jurchen Language of the Jin Dynasty*. Beijing.]

Тото = Tuotuo (1974). *Jin Shi*. Beijing: Zhonghua shuju. [Tuotuo (1974). *History of the Jin Dynasty*. Beijing: Zhonghua shuju.]

Jin Qicong (1984). *Nüzhwen cidian*. Beijing: Wenwu chubanshe. [Jin Qicong (1984). *Dictionary of the Jurchen Language*. Beijing: Wenwu chubanshe.]

Jin Qicong, Jin Guangping (1980). *Nüzhwen yuyan wenzi yanjiu*. Beijing: Wenwu chubanshe. [Jin Qicong, Jin Guangping (1980). *A Study of the Jurchen Language and Script*. Beijing: Wenwu chubanshe.]

Цинциус, В. И. (1975-1977). *Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков: Материалы к этимологическому словарю*. В двух томах. Ленинград: Наука. [Tsintius, V. I. (1975-1977). *Comparative Dictionary of Manchu-Tungusic Languages: Materials for an Etymological Dictionary*. In two volumes. Leningrad: Nauka.]

Shimunek, Andrew (2017). *Languages of Ancient Southern Mongolia and North China: A Historical-Comparative Study of the Serbi or Xianbei Branch of the Serbi-Mongolic Language Family, with an Analysis of Northeastern Frontier Chinese and Old Tibetan Phonology*. Wiesbaden: Harrassowitz Verlag.


Shimunek, Andrew (2018a). Early Serbi-Mongolic–Tungusic lexical contact: Jurchen numerals from the 室韋 Shirwi (Shih-wei) in North China. *Philology of the Grasslands*. Ed. Á. Apatóczky. Leiden: Brill. P. 331-346.

Shimunek, Andrew (2018b). Post-publication Addenda et Corrigenda to *Languages of Ancient Southern Mongolia and North China*. Revised by the author, January 20, 2018. www.academia.edu/34250361/Languages_of_Ancient_Southern_Mongolia_and_North_China_Addenda_et_Corrigenda_revised_2018_1_20

Shimunek, Andrew (2022). Toward a morphological paradigm of the Kitan verb ‘to give’ in Assembled Script and Linear Script, with notes on Mongolic cognates. *Altai Hakpo*, Volume 32. P. 71-98.

Товчилсон монгол үгс

ДЗүр.	Дундад үеийн зүрчид хэл буюу Middle Jurchen, ойролцоогоор 1450 он
ДМо.	Дундад үеийн монгол хэл
Ма.	Манж хэл
ӨСМ.	Өвөг сяньбэй-монгол хэл
СМ.	Сяньбэй-монгол төрлийн хэлнүүд буюу Serbi-Mongolic languages
ЭЗүр.	Эртний зүрчид хэл буюу Old Jurchen, ойролцоогоор 1115-1234 он
ЭМо.	Эртний монгол хэл буюу Old Mongol
ЭТүр.	Эртний түрэг хэл буюу Old Turkic



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.